

“Ажиглалт” ХХК

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2023 он

АГУУЛГА

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ:

- 1.1.Тулгарч байгаа асуудал, түүний мөн чанар, цар хүрээ
- 1.2.Тухайн асуудал үүссэн шалтгаан нөхцөл

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО:

- 2.1.Гол зорилго, зорилт

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАНУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАЛТ

- 3.1.Асуудлыг зохицуулалтын хувилбаруудыг тогтоох

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨНИЙ ТАЛААР

- 4.1.Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
 - 4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
 - 4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө
 - 4.1.3. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэх байгаа эсэх талаар

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТУУДЫН ХУВИЛБАНУУДЫГ ХАРЬЦУУЛАЛТ ДҮГНЭЛТ ХИЙХ

ЗУРГАА.ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХИ БУСАД ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Ашигт малтмалын тухай хуулийг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал /цаашид Аргачлал гэх/-ын 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Ашигт малтмалын тухай хууль нь Монгол Улсын геологи, уул уурхайн салбарын харилцааг зохицуулдаг гол хууль болохын хувьд салбарын оролцогчдын эрх ашгийг тэгш хангаж, газар, өмч, байгаль орчин, хөрөнгө оруулалтын эрх зүйн харилцааны харилцан уялдааг зохицуулсан байх шаардлагатай байдаг.

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1 Тулгарч байгаа асуудал, түүний мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, холбогдох бусад яамд, томоохон уул уурхайн компаниас нөхцөл байдлын талаарх лавлагаа, статистик тоон мэдээлэл цуглуулах, мөн асуудал хариуцсан мэргэжилтэн, мэргэжлийн холбоод, ТББ-ын төлөөлөлтэй ярилцлага хийх, эрх зүйн акт, энэ асуудлаар өмнө хийгдсэн судалгаа, тодорхой тохиолдлыг судлах хэлбэрээр чанарын мэдээлэл цуглуулсан болно.

Эрх зүйн зохицуулалт:

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь заалтад "... Газрын хэвлийн баялаг нь төрийн нийтийн өмч бөгөөд уг байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно." гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Ил тод хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж,

олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ.” гэж заасан.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын 3.7.10.Ашигт малтмалыг олон улсын зах зээлийн үнээр борлуулах боломжийг бүрдүүлж, эрдэс баялгийн салбараас орох орлогыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох арга, аргачлалыг боловсронгуй болгох; гэж зааснаар ашигт малтмалыг олон улсын зах зээлийн үнээр борлуулах бодлогыг баримтлахаар тус тус заасан.

Практик хэрэгжилтийн байдал:

Монгол Улс нь дэлхийд дээгүүрт орох ашигт малтмалын баялаг нөөцтэй бөгөөд нүүрс, зэс, молибден, алт, хайлуур жонш, газрын тос зэрэг 80 гаруй нэр төрлийн ашигт малтмалын нөөцтэй билээ. Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг шударга, нээлттэй ил тод зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтоох боломжийг хангах, экспортыг нэгдсэн бодлогоор зохицуулах замаар уул уурхайн салбарт хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд энэ салбарын оруулах хувь нэмрийг улам өргөжүүлэх шаардлага тулгараад байна.

Сүүлийн жилүүдэд уул уурхай, олборлох салбар өндөр хурдацтай хөгжиж 2005 оноос хойш дотоодын нийт бүтээгдэхүүнд энэ салбарын эзлэх хувийн жин 20 гаруй хувьд хүрсэн. Өнөөгийн байдлаар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 22 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 71 хувь, экспортын 94 хувийг бүрдүүлж буйн хувьд энэ салбар нь манай улсын эдийн засгийн тулгуур багана болж байна. Энэ ч агуулгаар уул уурхайн салбараас хүртэх орлогыг ил тод, хамгийн боломжит үнээр төвлөрүүлэх нь чухал юм.

Уул уурхайн бүтээгдэхүүний дотоод, гадаад зах зээлийн арилжаанд дараах хүндрэлүүд тулгарч байна:

- Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн бодит үнэ, худалдааны нөхцөл, бүтээгдэхүүний чанарын талаарх мэдээлэл нээлттэй ил тод бус байдгаас үр ашигтай гэрээ хэлцэл хийх боломж муу, зардал өндөр;
- Уул уурхайн бүтээгдэхүүнийг борлуулах зохион байгуулалттай зах зээл бий болоогүй улмаас бүтээгдэхүүний үнэ ханш дэлхийн зах зээлийн үнээс үлэмж доогуур;
- Гэрээний үндсэн дээр арилжаалагдах уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээ нь гэрээний үнээр тогтоогдож, хууль тогтоомжийн дагуу албан татвар, төлбөр, хураамжийг ногдож байна. Гэвч гэрээгээр тохирсон үнэ нь зах зээлийн ханшнаас үлэмж зөрүүтэй байдгаас уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтаас олох орлогыг ихээхэн бууруулж байна.
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дийлэнх нь хөрөнгө оруулалт байхгүй гэсэн шалтгаанаар үйл ажиллагаа явуулж чадахгүй байна.

- Хариуцлагагүй уул уурхайн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн бухимдлыг төрүүлэх болсон ба ард иргэдийн эрх ашиг, байгаль орчноо хамгаалах иргэний нийгмийн байгууллагуудын уул уурхайг эсэргүүцэх үйлдлүүд удаа дараа гарах болсон.
- Уул уурхайн бүтээгдэхүүний үнийн эрсдэлийг хамгаалах ирээдүйн фьючерсын гэрээг хийдэггүй, зах зээлийн өндөр үнээр дараа жилүүдэд үйлдвэрлэх бүтээгдэхүүнээ өндөр үнэтэй байхад нь борлуулж нэмэлт орлого олох боломжоо алдсаар байна.

Манай улсад Ашигт малтмалын тухай хуулийн агуулга нь нөхөн сэргээгдэхгүй баялгийг нийт улс орон, хүн ардын хэтийн сайн сайхны төлөө урт хугацааны бодлого зохицуулалттайгаар ашиглах зарчмыг дэмжихэд чиглэх учиртай.

Иймд төрийн нийтийн өмч болох газрын хэвлийн баялгийг зохисгүй ашиглалтаас хамгаалах, ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг нарийвчлах, салбарын үйл ажиллагаанаас байгаль орчин, олон нийтийн эрх ашигт үзүүлэх нөлөөллийн асуудлыг тэргүүн ээлжинд авч үзэн зохицуулах, салбарт оролцогчдын ашиг сонирхлыг тэнцвэртэй хангах байдлаар хариуцлагатай уул уурхайг дэмжих чиглэлд хуулийн зохицуулалтыг өргөжүүлэх шаардлага тулгарч байна.

Уул уурхайн салбараас хүртэх орлогыг ил тод, хамгийн боломжит үнээр төвлөрүүлэхэд олон хүндрэл бэрхшээл үүсдэг байна.

Тухайлбал:

Монголын уул уурхайн бүтээгдэхүүнийг худалдан авах сонирхолтой байгууллагуудад мэдээлэл тэгш байдлаар хүрдэггүйгээс зах зээлийн өрсөлдөөний зарчмаар эрдэс бүтээгдэхүүний худалдааг хийгдэж чадахгүй байгаа нь манай орны эрдэс баялгийн үнэлэмжийг ихээхэн бууруулж байна.

Улс бүр өөрийн үндэсний аюулгүй байдалд болон эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд шууд хамаарал бүхий ашигт малтмалыг “Чухал” бүлэгт хамааруулан зарлаж тухайн төрлийн ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, хөрөнгө оруулалтыг нэмэх чиглэлд тусгайлан бодлого гарган хэрэгжүүлж байна.

Иймд Монгол Улсын хувьд чухалд тооцогдох ашигт малтмалын төрлүүдийг тодорхойлж, түүнтэй холбоотой бодлогыг улсын хөгжлийн бодлогуудад тусгайлан тусгаж хэрэгжүүлэх, энгийн ашигт малтмалаас онцлог зохицуулалт, үйл ажиллагааны горимтой байх нөхцөлүүдийг хуулиар зохицуулах нь зүйтэй байна.

ТББ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас:

Хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгодог системийг сэргээх талаар салбарынхан хүсдэг, шаарддаг. Сонгон шалгаруулалтын журмаар олгох нь цөөн хэдэн мөнгөтэй компанийн ажил болж хувирч байгаа. Гэхдээ яам өргөдлийн тогтолцоог сэргээхээр ажиллаж байгаа байх. Энэ талаар ямар зохицуулалт байна вэ.

2023 оны байдлаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо 974 байна. Энэ тоо буурч байна. Бидний тооцоолсноор энэ хэвээр үргэлжилбэл 2024 он гэхэд хайгуулын тусгай зөвшөөрөл 400 орчим, бүр түүнээс ч бага болно. Хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо нь хувийн хөрөнгөөр гүйцэтгэх хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын хэмжээнд шууд нөлөөлдөг.

Иймд геологи хайгуулын салбар хүнд байдалд байна. 2017 оны 12 дугаар сард Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн сонгон шалгаруулалтын журмаар олгох болсон. Үүний гол шалтгаануудын нэг нь геологи хайгуулын салбарт хөрөнгө оруулалт хийж үр шимийг нь хүртэх зорилгоор бус, зөвхөн дамлан наймаалах зорилгоор авах сонирхолтой хүмүүсийн үйл ажиллагааг хязгаарлах алхам хийсэн гэж хардаг.

Гэвч 2018 оноос өнөөг хүртэл 3 жилийн хугацаанд сонгон шалгаруулалтын журмаар 90 тусгай зөвшөөрөл олгосон нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм. Иймд эхний ээлжид сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг тогтмол, ил тод, нээлттэй явуулах талаар анхаарч байна. Цаашлаад ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр хэрхэн шударга, ил тод олгох боломжийг судалж, шаардлагатай бол сонгон шалгаруулалтын болон үнэлгээний журмыг дахин авч үзэж зөв шударга болгох талаар тодорхой алхам хийгдэх ёстой. Магадгүй, хууль эрх зүйн орчныг сайжруулах, илүү боловсронгуй болгох алхам ч байж болно.

Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:

Уул уурхайн салбарт хувийн хэвшлийн оролцоо нээлттэй болсон сүүлийн 30-аад жилийн хугацаанд нөхөн сэргээлт, хаалтын эрх зүйн зохицуулалт хангалтгүй, тунхагийн шинжтэй, ёс төдий хэв шинжийг агуулсан цөөн тооны зохицуулалттайгаас эзэнгүй орхигдсон эвдэрсэн газрын хэмжээ 8 мянган га талбайд хүрч, хариуцлагагүй уул уурхайн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн бухимдлыг төрүүлэх болсон.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг:

1.Нийт иргэд Байгалийн баялгийн өгөөж нь өнөө болон ирээдүй үед зориулагдах ёстой. Иймд, байгалийн баялаг буюу уул уурхайн бүтээгдэхүүний үнэлгээг бодитой тогтоох нь бүх ард түмэнд хамааралтай.

2.Уурхай болон баяжуулах үйлдвэрийн хаалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь зүйтэй. Ашиглалтын болон баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгоход хаалтын төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулсан байхыг шаарддаг байх.

Эрх ашиг хөндөгдөх оролцогчдын хувьд явцын нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу хийснээр орон нутагт хууль бусаар үйл ажиллагаа эрхлэх асуудал гарахгүй болох мөн хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах боломж бүрдэх юм.

1.2 Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан:

Геологи, уул уурхайн салбарын талаарх бүх шатны нутгийн захиргааны байгууллага болон нутгийн байгууллагуудын эрх үүрэг давхардалтай эсхүл тодорхойгүйгээс, мөн хууль, эрх зүйн актуудад харилцан адилгүй зохицуулалттайгаас үүдэн салбарт оролцогчдын хооронд үл ойлголцол үүсэх, төрийн болон нутгийн захиргааны албан тушаалтнуудын эс үйлдэхүй түгээмэл гарах болсны дээр зохион байгуулалттай эсэргүүцлийн ажиллагаанууд газар авч, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг зогсоох, цаашлаад орон нутгийн төсвийн орлогыг тасалдуулах хүртэл сөрөг нөлөөг үзүүлэх болсон тул салбарын харилцаан дахь нутгийн захиргааны байгууллага, иргэд, олон нийтийн байгууллагын оролцоо, чиг үүрэгтэй холбоотой асуудал байна.

Мөн судалгаанаас харахад хүчин төгөлдөр 1728 ашиглалтын тусгай зөвшөөрөл байгаа ч үүнээс 450 нь төлөвлөгөө гаргаж, 250 нь л үйл ажиллагаа явуулж байгаа тайлангаа гаргаж байна. Үлдсэн 1400 ашиглалтын тусгай зөвшөөрлийн дийлэнх нь хөрөнгө оруулалт байхгүй гэсэн шалтгаанаар үйл ажиллагаа явуулж чаддаггүй байгаа нөхцөл байдал, олборлолт, баяжуулалтын үйл ажиллагааны туршид хаалтын төлөвлөлтийг бодит нөхцөл байдалд нийцүүлэх зэрэг өөрчлөлтүүдийг хуульд тодорхой тусгах шаардлага үүсч байна. Үүнд:

- Хуулийн хэрэгжилт орон нутагт хангалтгүй, орон нутагт хууль бусаар үйл ажиллагаа эрхлэх, салбарын талаарх мэдээлэл, иргэдийн ойлголтын зөрүү их зэрэг сөрөг үр дагавар гарч байгаа тул асуудал хариуцсан нэгжийг орон нутагт байгуулах;
- “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө”-г Засаг дарга баталдаг үүргийг өөрчлөх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулахдаа орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах.
- Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчинд гол нөлөөлөл үзүүлдэг үзүүлэлт бол Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн асуудлыг зохицуулах;
- Ашиглалтын болон баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгоход хаалтын урьдчилсан төлөвлөгөөг техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан боловсруулсан байхыг шаардах;

**ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН
БАЙДАЛ:**

Эрх зүйн зохицуулалтын хувьд. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн “ашигт малтмал ашиглах” гэдэг тодорхойлолтоос харахад Олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд тэр бүр боловсруулах үйлдвэрлэл эрхэлдэггүйгээс өөрөө олборлолт явуулдаггүй зөвхөн олборлосон ашигт малтмалыг олборлогчдоос худалдан авч ашигт агуулгыг нь нэмэгдүүлэх, баяжуулах, хагас боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг компаниуд олноороо бий болж байна.

Иймд Аргачлалын 4-т заасны шийдвэрлэх зорилтыг дараахь байдлаар тодорхойлж байна.

Зорилт:

- Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй хэрнээ ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа харилцааг салбарын эрх зүйн зохицуулалтад хамруулах.
- Одоогийн хуулийн хүрээн дэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ, татвар ногдох орлогыг тооцох аргачлал зэрэг нь оновчтой бус байгааг зохицуулах;
- Уурхай болон баяжуулах үйлдвэрийн хаалтын эрх зүйн зохицуулалтыг сайжруулан тусгах;

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй хэрнээ ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа харилцааг салбарын эрх зүйн зохицуулалтад хамруулах зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараахь дүгнэлтийг гаргалаа.

Хувилбар: Үр дүн

1. Хуулийн шинэчлэлээр ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй хэрнээ ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа харилцааг салбарын эрх зүйн зохицуулалтад бүрэн хамруулснаар тусгай зөвшөөрөлтэй эсэхээс үл хамаарч ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, экспортолсон этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байхаар Ашигт малтмалын тухай хуульд 2019 онд оруулсан өөрчлөлттэй холбоотой эрх зүйн зохицуулалт цогц байдлаар бүрдэнэ.

2. Уул уурхайн бүтээгдэхүүний дотоодын биржээс заралсан үнийг үндэслэн АМНАТ ногдуулдаг болох, АМНАТ-ыг шатлан ногдуулах, технологийн хувьд ялган ашигладаг эдийн засгийн үр ашигтай дагалдах элементэд АМНАТ ногдуулах зэрэг

өнөөгийн практикт асуудал хүндрэл бэрхшээл дагуулдаг асуудлуудыг олон улсын жишгийг харгалзан боловсронгуй болно.

3. Хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх зорилтын хүрээнд уурхай болон баяжуулах үйлдвэрийн хаалтын эрх зүйн зохицуулалтыг тусгаж, уг харилцааг боловсронгуй болно.

Үр дүн сөрөг

1.Хяналтгүйгээр худалдан авч хууль бус олборлолтыг өөхшүүлэх, татвараас зайлхийхээс гадна баяжуулалтын дүрэм журам, технологи, стандарт, норм зөрчигдөх, хортой бодис урвалжийг ил далд байдлаар хяналтгүй ашиглах, хаягдлын далан, аж ахуйн горим алдагдах, хүрээлэн буй орчинд эрсдэл үүсгэх, хаалтын болон явцын мониторинг хийгдэхгүй байх зэрэг олон сөрөг үр дагавар үүсэхээс сэргийлж Тодорхой үр дүнд хүрнэ.

2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны үүрэг хариуцлага болон техник, технологийн шаардлагуудаас зайлсхийх зорилгоор үүсмэл ордыг дахин ашиглалгүй бусдад худалдах, түрээслэх, өөр аж ахуйн нэгжийн нэр дээр баяжуулалт хийх замаар татвар, хураамж төлөхгүй байх арга замыг эрэлхийлэх тохиолдлууд гарсаар байгаа тул ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн үүсмэл ордыг өөрөө ашиглах хөшүүргийн механизм бүрдэнэ.

3.Тусгай зөвшөөрлийн тухай зохицуулалтыг хуульд шинээр тусгаснаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахгүй байх, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанаас үүссэн үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд *баяжуулалтын тусгай зөвшөөрлийн* үндсэн дээр ашиглахаар зохицуулалтыг тусгаснаар тодорхой үр дүнд хүрнэ.

4. Одоогийн хуулийн хүрээн дэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ, татвар ногдох орлогыг тооцох аргачлал зэрэг нь оновчтой бус байгаагийн дээр давхардуулж ногдуулах, дагалдах эрдэс болон хортой хольцод ногдуулах зэрэг зохицуулалтууд нь салбарын хөрөнгө оруулалтад нөлөөлөхөөс гадна, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд татварын дарамтаас зайлсхийх зорилгоор чанар, агуулга багатай хэсгийг ашиглахгүй орхих эсхүл овоолготой хольж баялгийг үнэгүйдүүлэх зэргээр ордыг сорчлон ашиглах хандлага нэмэгдэх болж салбарын хөгжилд сөргөөр нөлөөлж байгааг засч сайжруулна.

5. Хаалтын эрх зүйн зохицуулалтыг олборлолт, баяжуулалтын үйл ажиллагааны туршид тодорхой давтамжтайгаар тодотгож байхаар хуульд зохицуулснаар уул уурхайн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн бухимдал багасч ард иргэдийн эрх ашиг, байгаль орчноо хамгаалах, хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэхэд чухал түлхэц болно.

Гарах зардлын хувьд:

5.Ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайг илрүүлэх эрлийн ажлыг явуулах улсын төсвийн хөрөнгө төдийлөн хангалтгүй буюу төсвийн боломжоос хамаарч судалгааны цар хүрээ хязгаарлагдаж байгаа тул хувийн хөрөнгөөр эрэл хийх боломжийг нээж өгөх нь үр дүнтэй юм.

Одоогийн хууль тогтоомжийн хүрээнд геологийн суурь судалгаа, эрлийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх зохицуулалттай байна.

Харьцуулалтын үр дүнг харгалзан үзвэл дараахь 4 хувилбар илүү эерэг нөлөөтэй байх магадлалтай байна:

- Хувилбар-1: Улсын болон хувийн аль ч хөрөнгөөр хийсэн эрлийн ажлын үр дүнгээр ашигт малтмалын хэтийн төлөв тогтоогдвол уг талбайг хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын талбайд хамруулж, нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох, хувийн хөрөнгөөр эрэл хийх боломжийг нээж өгөх нь салбарын хөгжилд түлхэц болох сайн талтай.

Хувилбар-2: Хуулиар хориглосноос бусад газарт ашигт малтмалын эрлийн үйл ажиллагаа явуулахад хувийн хэвшлийн оролцоог нээлттэй болгож, холбогдох төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулах замаар, тусгай зөвшөөрөл шаардахгүйгээр, өөрийнх нь зардлаар эрлийн ажлыг гүйцэтгүүлж болох боломжийг бий болгох.

Хувилбар-3. Иймд хуулийн шинэчлэлийн хүрээнд Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ("АМНАТ")-ийн төрлийг нарийвчлан тодорхойлж, АМНАТ ногдуулах орлогыг тооцох, ногдуулах, төлөхтэй холбоотой харилцааг илүү оновчтой болгох.

Хувилбар-4. Хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх зорилтын хүрээнд уурхай болон баяжуулах үйлдвэрийн хаалтын эрх зүйн зохицуулалтыг тусгаж, харилцааг боловсронгуй болгох;

Хувилбаруудын эерэг, сөрөг талын харьцуулалтын үр дүнгийн дагуу сонгосон хувилбарт ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаа явуулахыг хориглосон болон тусгай горимоор явуулах талбайд зөвхөн улсын төсвийн хөрөнгөөр эрлийн ажил хийх, үр дүнд нь хэтийн төлөв тогтоогдвол хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн дунд зохион байгуулахаар хязгаарлах нь зүйтэй байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний дотоодын биржээс заралсан үнийг үндэслэн АМНАТ ногдуулдаг болох, АМНАТ-ыг шатлан ногдуулах, технологийн хувьд ялган ашигладаг эдийн засгийн үр ашигтай дагалдах элементэд АМНАТ ногдуулах зэрэг өнөөгийн практикт асуудал хүндрэл бэрхшээл дагуулдаг асуудлуудыг олон улсын жишгийг харгалзан боловсронгуй болгох нь зүйтэй.

Иймд тухайн хуулийн төслийн агуулга, зохицуулалтын хэлбэрийг дараахь байдлаар ерөнхийлөн томъёолж байна.

Тус хуулиар Монгол Улсын геологи, уул уурхайн салбарын харилцааг зохицуулдаг гол хууль болохын хувьд салбарын оролцогчдын эрх ашгийг тэгш хангаж, газар, өмч, байгаль орчин, хөрөнгө оруулалтын эрх зүйн харилцааны харилцан уялдааг нарийн зохицуулсан байх шаардлагатай.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ

Тандан судалсан байдал

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон 2 хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич:Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдал.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хувилбар 1, 2-ын хүрээнд Улсын болон хувийн аль ч хөрөнгөөр хийсэн эрлийн ажлын үр дүнгээр ашигт малтмалын хэтийн төлөв тогтоогдвол уг талбайг хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын талбайд хамруулж, нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох,хувийн хөрөнгөөр эрэл хийх боломжийг нээж өгөх нь салбарын хөгжилд түлхэц болох сайн талтай.оролцогчийн эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шалгуурыг тогтоох нь тэгш бус, ялгамжтай байдлыг арилгах, мөн нийгэм болон хэрэглэгчдийг эрсдлээс хамгаалах, хариуцлагыг нэмэгдүүлэх, тодорхой санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зэргээр хүний эрхийг дэмжих, хангахад чиглэсэн зохицуулалтыг бий болгоно.

Хуулиар хориглосноос бусад газарт ашигт малтмалын эрлийн үйл ажиллагаа явуулахад хувийн хэвшлийн оролцоог нээлттэй болгож, холбогдох төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулах замаар, тусгай зөвшөөрөл шаардахгүйгээр, өөрийнх нь зардлаар эрлийн ажлыг гүйцэтгүүлж болох боломжийг бий болгох, дээшлүүлэх, тодорхой чиглэлд уул уурхайн бүтээгдэхүүний чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэгдэх тул ялгаварлан гадуурхалт биш юм.

Иймд эдгээр асуудлыг цогцоор шийдвэрлэхийн тулд хуулиар зохицуулах нь илүү нөлөөтэй байна.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Сонгосон хоёр хувилбарын аль аль нь төрийн байгууллагын зардал, хүний нөөцийг хэмнэх чиглэлд улсын болон орон нутгийн төсөвт тодорхой хэмнэлтийг бий болгохын зэрэгцээ төрийн үйлчилгээнд инноваци болон түүнтэй холбогдох судалгаа шинжилгээний ажлыг нэвтрүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Дээрх хоёр зохицуулалтыг аль ч хувилбарыг хэрэгжүүлсэн тодорхой зардал гарах боловч хариуцсан төрийн байгууллагын чиг үүрэгт нэмэлт, өөрчлөлт бий болгохгүй, харин үйл явц илүү тодорхой, ил тод болно.

4.3. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хувилбарууд бүгд байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй. Байгалийн баялаг ашиглалт, нөхөн сэргээлтийн чиглэлд энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд үйл ажиллагааг дээшлүүлж, байгаль орчны хяналтыг нэмэгдүүлэх сайн талтай.

4.4. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь заалтад "... Газрын хэвлийн баялаг нь төрийн нийтийн өмч бөгөөд уг байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно." гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 19.1-д "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн олон бусад баталгааг бүрдүүлэх" хэмээн хуульчилсан. Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлд эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох, өндөр наслах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдлаас хамгаалуулах, хууль зүйн туслалцаа авах гэх зэрэг иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулсан. Хүний эрх, эрх чөлөө нь түгээмэл, зайлшгүй бөгөөд өөр хоорондоо харилцан хамаарал бүхий байдаг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах нь төрийн үндсэн чиг үүрэг билээ. Төр энэхүү үүргээ хэрэгжүүлэх хүрээнд байгалийн баялгийн ашиглалтаас хүртэх үр өгөөжийг бодитой тогтоох, өнөө болон ирээдүй хойчийн үндсэн хуулиар олгосон эрх, эрх чөлөөг эдлүүлэх боломжийг тодорхой хууль тогтоомж, эрх зүйн актаар нээсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Ил тод хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ." гэж заасан.

Иймд дээрх хувилбарууд нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй болно. Харин Үндсэн хуулийн

оршил хэсэгт тодорхойлсон "... хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн цогцлоон хөгжүүлэх" зорилтыг хэрэгжүүлэхэд ихээхэн дэмжлэг болно хэмээн дүгнэж байна.

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараахь дүгнэлтийг хийлээ.

Хувилбар 1 буюу хууль батлан хэрэгжүүлэх нь өнөөгийн тулгамдаад байгаа сөрөг үр дагаварыг бууруулах, хяналт, үр дүнг сайжруулах зэрэг асуудлыг цогцоор шийдвэрлэх боломж өндөр байна.

ЗУРГАА.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Бусад орны эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлах хүрээнд энэ чиглэлээр өмнө хийгдсэн судалгааны мэдээлэлд үндэслэн тодорхой нөхцөлийг тодруулах зорилгоор дараахь улсуудыг сонгон авсан:

Зарим орны ашигт малтмалын хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох боломжгүй газар нутгийн эзлэх хувийг авч үзвэл Оросын Холбооны Улс-13.5%, Бүгд Найрамдах Казахстан Улс-8.2%, Бүгд Найрамдах Армени Улс-12.9%, Гүрж Улс-9.6%, Украин Улс-8.1%, Австрали Улс – 19.7%, Канад Улс – 12.1%, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс – 44.5%, Чили Улс – 21%, Бүгд Найрамдах Беларусь Улсад 9%-ийг эзэлж байна. Ангиллаар нь авч үзвэл дархан цаазат газар, үндэсний цогцолборт газарт, байгалийн цогцолборт газар, улсын нөөц газар, байгалийн дурсгалт газар, цэцэрлэгт хүрээлэн зэрэг багтаж байна.

Ийнхүү адил төстэй орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр хувиар салбарын үйл ажиллагааг хориглосон, хязгаарласан талбай тогтоосон нь салбарын хөгжлийг илт хумьж, улсын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх үр дагавартай юм.

Ашигт малтмалын тухай хуулиар дээрх байдлаар хориглосон, хязгаарласан талбайнуудыг нэр дурдаж заагаагүй боловч бусад хуулиудаар улсын тусгай

хэрэгцээнд авсан газруудад хязгаарлах, хориглох асуудал зохицуулагдаж ирсэн нь хууль хоорондын зөрчил, давхардал, хийдэл ихээр үүсгэж байна.

Иймд хуулийн төслөөр улсын тусгай хамгаалалттай газар, улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар, байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай, цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар, аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, онцгой хамгаалалтын бүсэд ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулахыг хориглох, зам, шугам, ойн сан бүхий газар, улсын хилийн зурвас газар, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд тусгай горимоор явуулж болохоор тусгах нь зүйтэй.

ДОЛОО.ЗӨВЛӨМЖ

Ашигт малтмалын тухай хуулийн зохицуулалтыг сайжруулах чиглэлд тодорхой ахиц гарсан ч хуулийн агуулга, зорилго алдагдаж, анх батлагдсан үзэл баримтлалдаа нийцэхгүй болсноор салбарт хуулийн оновчтой зохицуулалт дутагдаж, улс орны эдийн засгийн тэргүүлэх салбарын хөгжлийг сааруулах, өрсөлдөх чадварыг алдагдуулах, хөрөнгө оруулалтыг бууруулах эрсдэлд хөтөлж байна.

Мөн Монгол Улсын Үндсэн Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, эрх зүйн харилцаанд гарсан томоохон өөрчлөлтүүд, Монгол Улсын хөгжлийн бодлогын тулгуур болсон эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох зорилт нь хуулийн цогц шинэчлэлийг шаардаж байна.

Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/67 дугаар тушаалаар “Уул уурхайн салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах” үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан Ашигт малтмалын тухай болон эрдэс баялгийн салбарт мөрдөж байгаа 10 хуульд дүн шинжилгээ хийж, нийт 267 давхардал, 150 зөрчил, 150 хийдэл байгааг тогтоосон нь тус салбарт дахь эрх зүйн орчны гажуудлыг залруулах шаардлагыг харуулж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа, байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлт, уурхай, үйлдвэрийн хаалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, орон нутгийн уялдаа холбоо, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэрэг салбарын үйл ажиллагаатай холбоотой бүхий л асуудлыг хамарсан эрх зүйн шинэлэг зохицуулалтыг бий болно.

Тусгай зөвшөөрлийг цуцлах, хүчингүй болгох үндэслэлийг цөөлж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн харилцааг оновчилж, салбарын үйл ажиллагаан дахь байгаль орчин, орон нутгийн харилцаа, иргэд, олон нийтийн оролцооны зохицуулалтыг боловсронгуй болгож, эдгээр үйл ажиллагаан дахь хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгаснаар салбарт хөрөнгө оруулагчдын идэвхи, итгэлийг нэмэгдүүлж, уул уурхайн төслүүд амжилттай хэрэгжих боломж бүрдэж, цаашлаад салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлж

экспорт нэмэгдэж, валютын нөөц, улсын эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлнө.

Салбарын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг хуульчилж, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлагыг нарийвчилж, тусгай зөвшөөрлийн төлбөр, хүчинтэй хугацааг уялдуулан шинэчилж, газрын хэвлийн баялгийг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр, үйлдвэрлэлийн аргаар ашиглах зарчмыг баримталж, уурхай, үйлдвэрийн хаалтын шинэ тогтолцоог санхүүгийн баталгааны механизмтай уялдуулан бий болгосноор хариуцлагатай уул уурхайн тогтолцоо улам бэхжинэ. Ингэснээр салбарын талаарх олон нийтийн ойлголт, итгэл нэмэгдэж, эсэргүүцэл багасна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, аж ахуйн нэгжүүдийн үүрэг оролцоо, хамтын ажиллагаа, хяналтын тогтолцоо тодорхой болж, нээлттэй, ил тод орчин бүрдэнэ.

---oO---

ХАВСРАЛТ

Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага:

-П.Очирбат, “Монгол Улсын эрдэс баялгийн цогцолборын хөгжлийн стратеги ба экологи”, Улаанбаатар, 1998

-Я.Гомбосүрэн, “Эрдсийн баялгийн олборлолт, боловсруулалтын технологи, экологи-эдийн засгийн үнэлгээний онол, арга зүй”, Улаанбаатар, 2004

-Я.Гомбосүрэн, Монголын ашигт малтмалын ордууд, Улаанбаатар, 1977

-Д.Галсандорж, Д.Бат-Эрдэнэ, Ц.Мөнхжаргал, Монгол улсын уул уурхайн бүтээгдэхүүний олон улсын худалдаа, өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд, Олон улс судлал сэтгүүл, 2011 №2

Хууль тогтоомжийн жагсаалт

-Монгол Улсын Үндсэн хууль

-Хууль тогтоомжийн тухай хууль

-Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай

-Ашигт малтмалын тухай хууль

---oO---

ХАВСРАЛТ

Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага:

-П.Очирбат, “Монгол Улсын эрдэс баялгийн цогцолборын хөгжлийн стратеги ба экологи”, Улаанбаатар, 1998

-Я.Гомбосүрэн, “Эрдсийн баялгийн олборлолт, боловсруулалтын технологи, экологи-эдийн засгийн үнэлгээний онол, арга зүй”, Улаанбаатар, 2004

-Я.Гомбосүрэн, Монголын ашигт малтмалын ордууд, Улаанбаатар, 1977

-Д.Галсандорж, Д.Бат-Эрдэнэ, Ц.Мөнхжаргал, Монгол улсын уул уурхайн бүтээгдэхүүний олон улсын худалдаа, өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд, Олон улс судлал сэтгүүл, 2011 №2

Хууль тогтоомжийн жагсаалт

-Монгол Улсын Үндсэн хууль

-Хууль тогтоомжийн тухай хууль

-Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай

-Ашигт малтмалын тухай хууль

---oO---